



ӨМНӨГОВЬ АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар A/05

Даланзадгад

Халдварын сэргийлэлт, хяналтын алба  
байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 11 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 186 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2017 оны А/1211 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад халдварын сэргийлэлт, хяналтыг зохион байгуулах, хамтран ажиллах, хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагаанд дотоодын хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус Халдварын сэргийлэлт, хяналтын албыг байгуулсугай.
2. Халдварын сэргийлэлт, хяналтын багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Халдварын сэргийлэлт хяналтын алба нь халдвараас сэргийлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, улирал тутам тайлангаа салбар зөвлөлд танилцуулан ажиллахыг Халдварын сэргийлэлт, хяналтын алба /Б.Бямбажав/-нд үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ӨНӨРЖАРГАЛ

Эрүүл мэндийн газрын даргын 2018  
оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн  
A/05 дугаар тушаалын Нэгдүгээр  
хавсралт

9347751  
КОДАЛДАА

ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Албаны дарга:
- Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
- Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтсийн сувилахуйн тусlamж хариуцсан мэргэжилтэн
  - Эрүүл мэндийн газрын Эмнэлгийн тусlamж үйлчилгээний хэлтсийн эмийн бодлогын мэргэжилтэн
  - Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн төвийн мэдээлэл сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
  - Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн хүний нөөцийн мэргэжилтэн
  - Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн эдийн засагч

Эрүүл мэндийн газрын даргын 2018  
оны 01 дугээр сарын 19-ний өдрийн  
A/05 дугаар тушаалын хоёрдугаар  
хавсралт

904775-  
КОА002-

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТЫН АЛБАНЫ ЧИГ ҮҮРЭГ

- Халдвартын сэргийлэлт, хяналтын чиглэлээр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн биелэлтийг хангуулж, хяналт тавьж ажиллана;
- Халдвартын сэргийлэлт хяналтын төлөвлөгөөтэй ажиллана;
- Халдвартын сэргийлэлт, хяналтад шаардагдах санхүүжилтийг салбар зөвлөлд танилцуулна;
- Эрүүл мэндийн байгууллагын түвшинд ЭТҮХХ-ын эрсдэлийг бууруулах, сэргийлэх, хянахад нэгдмэл байдлаар буюу бүх хүний оролцоог ханган ажиллана;
- ЭТҮХХ-аас сэргийлэх асуудлаар эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн байгууллагатай хамтран сургалт зохион байгуулж, мэргэжилт арга зүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллана;
- ЭТҮХХ-ын тандалт судалгаа хийж, халдвартыг эрт илрүүлэн мэдээлж, хариу арга хэмжээ авна;
- ЭТҮХХ-ын тохиолдлыг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулна; Онош баталгаажуулах, давтан шинжилгээ хийх зорилгоор эмнэлзүйн сорьц, нянгийн омгийг зохих нөхцөлд хадгалсан байна;
- ЭТҮХХ-ын дэгдэлт гарсан болон халдвартыг эрсдэл бий болсон үед хариу арга хэмжээ авахад тухайн эрүүл мэндийн байгууллагын чадамж хүрэхгүй тохиолдолд мэргэжлийн туслалцаа авч ажиллана;
- Нянгийн тэсвэржилттэй уялдуулан нянгийн эсрэг эм, бэлдмэлийн зохистой хэрэглээг төлөвшүүлж ажиллана.
- Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчид, тэдний ар гэрийнхэнд шаардлагатай мэдээлэл өгнө;
- Тандалт, судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийж харьяалах болон бусад тасаг нэгж, эрүүл мэндийн ажилтнуудад эргэн мэдээлнэ;
- Үйлчлүүлэгчийн эрүүл мэнд болон лабораторийн шинжилгээний үр дүн (олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагдаг халдвартыг олон эмэнд тэсвэртэй нянгийн халдвартай зэрэг)-г цаг алдалгүй мэдээлнэ;
- Үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцлалыг хадгална;
- Эрүүл мэндийн ажилтныг халдварт өртөх эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг авч ажиллана;
- Эмнэлгийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариун цэврийн бүтээгдэхүүн, хувийн хамгаалах хувцас, хэрэгслийн тооцоог гаргана;
- Халдвараас сэргийлэх дэглэмийн зөрчил, алдаа дутагдлыг бүртгэж, арилгуулах арга хэмжээг авна;
- Халдвартын сэргийлэлт, хяналтын чиглэлээр амжилт гаргасан, дэмжлэг үзүүлсэн байгууллага, тасаг, нэгж, эмнэлгийн ажилтнуудын үйл ажиллагаа, туршлагыг сурталчилж, урамшуулна;